БАТЛАВ
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ______ Ш. БАЯНМӨНХ

БАТЛАВ
ГРАНДАВТО ЛАНД ХХК-ИЙН
ЗАХИРАЛ ______ А.БҮРЭНМЭНД

***АЖЛЫН БАГАЖ ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ***

Дугаар № 78/2022

2022 оны 07-р сарын 19 өдөр Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх нөгөө талаас Грандавто ланд ХХК-ийг төлөөлж захирал А.Бүрэнмэнд /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дах заалт, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ”гэх) байгуулав.

**Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл**

1.1. Нийлүүлэгч нь ”**Ажлын багаж хэрэгсэл**” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтанд заасан барааг нэр төрөл, тоо хэмжээ, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

**Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа**

2.1. Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш 30 /гуч/ хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

**Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл**

3.1. Энэ гэрээний нийт үнэ 25,094,300 /Хорин таван сая ерэн дөрвөн мянга гурван зуу/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль Онцгой албан татвар, Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх тээврийн зардал НӨАТ бүгд шингэсэн байна.
3.2. Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.
3.3. Барааг хүлээлгэн өгсөний дараа бараа хүлээн авсан баримт, гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш 90 ер/ хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Голомт банкны 1410003644 тоот дансанд шилжүүлнэ.

**Дөрөв.Талуудын хүлээх хариуцлага**

4.1. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
4.2. Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.

4.3.Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсэний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.

4.4.Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Зуухан цехийн дарга Э.Ариунболд хариуцан ажиллана. Утас- 99727172.

4.5.Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Грандавто ланд ХХК-ийн захирал А.Бүрэнмэнд хариуцан ажиллана. Утас- 99116360, 94665545.

## Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

5.1.Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.

5.2.Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед гэмтэх, хэмхэрэхээс хамгаалсан сав, баглаа боодолтой, шинэ байна.

5.3.Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.

5.4.Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

5.5. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл, доголдлыг өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.

## Зургаа. Бараа хүлээн авах

6.1.Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.

6.2.Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

## Долоо. Давагдашгүй хүчин зүйл

7.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.

7.2.Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 10 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

## Найм. Гэрээг цуцлах үндэслэл

8.1. Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө.Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлах ба баталгааг буцаан олгохгүй.

8.2.Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

## Ес. Бусад нөхцөл

9.1. Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 10 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
9.2. Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
9.3. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
9.4. Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
9.5. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
9.6. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
9.7. Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ
Ө.УДВАЛ
Гарын үсэг:

ТҮЛШ ДАМЖУУЛАХ ЦЕХИЙН ДАРГА
Д.ТҮВШИНЗАЯА
Гарын үсэг:

ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА
Э.АРИУНБОЛД
Гарын үсэг:

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
Г.САРУУЛ
Гарын үсэг:

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН
Ш.ГАНТУЛГА
Гарын үсэг:

*Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1*
*Утасны дугаар: 77111251*
РД: 6021646

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ГРАНДАВТО ЛАНД
ХХК-ИЙН ЗАХИРАЛ
А. БҮРЭНМЭНД
Гарын үсэг:

*Хаяг: СХД 12-р хороо ханайн 23-500 тоот*
*Утас: 94665545*
*РД:5513057.*

Тоот гэрээний хавсралт

АЖЛЫН БАГАЖ ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ ЖАГСААЛТ

| № | Бараа материалын нэрс | Марк | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | Төмрийн өрөм /конус/ | 5мм-32мм | Ком | 1 |
| 2 | Төмрийн өрөм /цлиндр/ | 5мм-32мм | Ком | 1 |
| 3 | Гагнуурын держатель | солонгос /дүйцэхүйц/ | ш | 3 |
| 4 | Метечки 1/2 орос /дүйцэхүйц/ | 10мм-32мм | ком | 1 |
| 5 | Плашки 1/2 орос /дүйцэхүйц/ | 10мм-32мм | ком | 1 |
| 6 | Резьбамер | орос/дүйцэхүйц/ | ш | 2 |
| 7 | Гагнуурын шил цагаан | цагаан | ш | 250 |
| 8 | Гагнуурын масны хавчаар | Солонгос/дүйцэхүйц/ | ш | 4 |
| 9 | Плазм зүсэгчийн хошуу | Солонгос/дүйцэхүйц/ | ш | 50 |
| 10 | Тусгай түлхүүр 6талт /1-10мм / | TAJIMA/дүйцэхүйц | ш | 5 |
| 11 | Тусгай түлхүүр 6 талт /10-17мм/ | TAJIMA/дүйцэхүйц | ш | 2 |
| 12 | Газови /10" / | TAJIMA/дүйцэхүйц | ш | 4 |
| 13 | Газови /24" / | TAJIMA/дүйцэхүйц | ш | 4 |
| 14 | Товуд шиприз | | ш | 2 |
| 15 | Түлхүүр 18мм | TAJIMA/дүйцэхүйц | ш | 6 |
| 16 | Троцовны иш том, дунд,жижиг иш тус бүр -1ш | TAJIMA/дүйцэхүйц | ш | 3 |
| 17 | Метр / 3-5метр/ | Солонгос/дүйцэхүйц | ш | 2 |
| 18 | Зөөлөн тросс /ф5мм урт нь 20-60см/ | Ф5мм урт нь 20-60см | ш | 4 |
| 19 | 2 Дэгээтэй тросс /ф10мм/ | ф10мм | ш | 2 |
| 20 | Отвёртикны ком | TAJIMA/дүйцэхүйц | ш | 2 |
| 21 | Түлхүүр /55мм,50мм,46мм,36мм,41мм тус бүр -2ш/ ком | TAJIMA/дүйцэхүйц | ком | 1 |
| 22 | Дроцовны ком /8-36мм/ | TAJIMA/дүйцэхүйц | ш | 1 |
| 23 | Төмрийн маркер | Цагаан | ш | 10 |
| 24 | Тэгш ус | Барилгын / богино / | ш | 1 |
| 25 | Гагнуурын баг | | ш | 2 |
| 26 | Гагнуурын держатель | | ш | 4 |
| 27 | Гагнуурын багны хар шил | C3:C4 | боодол | 2 |
| 28 | Алмаз шил зүсэгч | | ш | 4 |
| 29 | Жижиг тасдагч гар | /Макита/дүйцэхүйц | ш | 1 |
| 30 | Тэнжээ | 2тн | хос | 1 |
| 31 | Тэнжээ | 5тн | хос | 1 |
| 32 | Краны строп | /5тн/ | ш | 1 |
| 33 | Өтгөн тосны гар насос | | ш | 2 |
| 34 | Өтгөн тосны хөл насос | | ш | 1 |
| 35 | Лантуу | 5кг | ш | 5 |
| 36 | Хүрз | 5кг хумбан | ш | 30 |
| 37 | Газовын ком | /Tajima//дүйцэхүйц | Ком | 2 |
| 38 | Төмрийн хайч | орос/дүйцэхүйц | ш | 2 |
| 39 | Пронцосс | 22-36 | ш | 5 |
| 40 | Штангенциркуль | 0-150 | ш | 2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 41 | /Макилта/ молоток /жижиг/ | Макилта/дүйцэхүйц | ш | 1 |
| 42 | Олс | | м | 50 |
| 43 | Силиконы буу | KEN /дүйцэхүйц/ | ш | 1 |
| 44 | Хадаас тавлагч | KEN /дүйцэхүйц/ | ш | 1 |
| 45 | Жижиг түлхүүрийн ком | 4-20мм хүртэл сонголтоор | ком | 1 |
| 46 | Тусгай түлхүүр | toptul /дүйцэхүйц/ | ш | 1 |
| 47 | Ажилчдын багажны цүнх | Үүрдэг | ш | 16 |
| 48 | Холхивч тослох шиприз | Хөдөлгүүрийн холхивч тослоход хэрэглэх | ком | 1 |
| 49 | Халим | Цахилгааны тусгаарлагатай байх | Ком | 14 |
| 50 | Тестерийн шүб | | ш | 12 |
| 51 | Хүрзний иш | Модон | ш | 5 |
| 52 | 2 дугуйт тэргэнцэр | Шаврын | ш | 2 |
| 53 | Хүрз /хавтгай/ | 5кг | ш | 10 |
| 54 | Хагас автомат гагнуурын аппаратны хошуу | металл | ком | 5 |
| 55 | Өтгөн тосны масленка | 8-11мм | ш | 100 |
| 56 | Аваарын троссын хомут | | ш | 10 |
| 57 | Аргон гагнуурын ком багаж | | иж бүрдэл | 1 |

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА Э.АРИУНБОЛД

ГРАНДАВТО ЛАНД ХХК-ИЙН
ЗАХИРАЛ А.БҮРЭНМЭНД

ГРАНД АВТО ЛАНД ХХК
GRAND AUTO LAND Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ
УЗМ02237 5513037

# "Грандавто ланд" ХХК

**Барааны үнийн задаргаа**

| № | Нэр | Гарал үүслийн улс | Хэмжих нэгж | Хэмжих нэгж | Нэгж үнэ | Нэр төрөл бүрийн бүгд үнэ | Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ | Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж | Нэр төрөл бүрийн нийт үнэ | Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төмрийн өрөм /конус/ 5мм-32мм | | Ком | 1 | 100,000 | 100,000 | 1,000 | 10,100 | 111,100 | Үгүй |
| 2 | Төмрийн өрөм /цилиндр/ 5мм-32мм | | Ком | 1 | 100,000 | 100,000 | 1,000 | 10,100 | 111,100 | Үгүй |
| 3 | Гагнуурын держатель | солонгос | ш | 3 | 50,000 | 150,000 | 3,000 | 15,300 | 168,300 | Үгүй |
| 4 | Метечки 1/2 орос 10мм-32мм | ОХУ | ком | 1 | 300,000 | 300,000 | 1,000 | 30,100 | 331,100 | Үгүй |
| 5 | Плашки 1/2 орос 10мм-32мм | ОХУ | ком | 1 | 300,000 | 300,000 | 1,000 | 30,100 | 331,100 | Үгүй |
| 6 | Резьбамер | ОХУ | ш | 2 | 50,000 | 100,000 | 2,000 | 10,200 | 112,200 | Үгүй |
| 7 | Гагнуурын шил цагаан | БНХАУ | ш | 250 | 5,000 | 1,250,000 | 250,000 | 150,000 | 1,650,000 | Үгүй |
| 8 | Гагнуурын масны хавчаар | Солонгос | ш | 4 | 50,000 | 200,000 | 4,000 | 20,400 | 224,400 | Үгүй |
| 9 | Плазм зүсэгчийн хошуу | Солонгос | ш | 50 | 50,000 | 2,500,000 | 50,000 | 255,000 | 2,805,000 | Үгүй |
| 10 | Тусгай түлхүүр 6 талт /1 -10мм / | АНУ | ш | 5 | 60,000 | 300,000 | 5,000 | 30,500 | 335,500 | Үгүй |
| 11 | Тусгай түлхүүр 6 талт /10-17мм/ | АНУ | ш | 2 | 90,000 | 180,000 | 2,000 | 18,200 | 200,200 | Үгүй |
| 12 | Газови/10"/ | АНУ | ш | 4 | 80,000 | 320,000 | 4,000 | 32,400 | 356,400 | Үгүй |
| 13 | Газови/24" / | АНУ | ш | 4 | 90,000 | 360,000 | 4,000 | 36,400 | 396,800 | Үгүй |
| 14 | Товуд шиприз | ОХУ | ш | 2 | 50,000 | 100,000 | 2,000 | 10,200 | 112,200 | Үгүй |
| 15 | Түлхүүр 18мм | АНУ | ш | 6 | 20,000 | 120,000 | 6,000 | 12,600 | 138,600 | Үгүй |
| 16 | Троцовны иш том, дунд,жижиг иш | АНУ | ш | 3 | 50,000 | 150,000 | 3,000 | 15,300 | 168,300 | Үгүй |
| 17 | Метр / 3-5метр/ | Солонгос | | 2 | 30,000 | 60,000 | 2,000 | 6,200 | 68,200 | Үгүй |
| 18 | Зөөлөн тросс /ф5мм урт: 60см/ | ОХУ | ш | 4 | 50,000 | 200,000 | 4,000 | 20,400 | 224,400 | Үгүй |
| 19 | 2 Дэгээтэй тросс /ф10мм/ | ОХУ | ш | 2 | 100,000 | 200,000 | 2,000 | 20,200 | 222,200 | Үгүй |
| 20 | Отвёртикны ком | АНУ | ш | 2 | 80,000 | 160,000 | 2,000 | 16,200 | 178,200 | Үгүй |
| 21 | Түлхүүр /55мм,50мм,46мм,36мм,41мм тус бүр -2ш/ ком | АНУ | ком | 1 | 200,000 | 200,000 | 1,000 | 20,100 | 221,100 | Үгүй |
| 22 | Дроцовны ком /8-36мм/ | АНУ | | 1 | 200,000 | 200,000 | 1,000 | 20,100 | 221,100 | Үгүй |
| 23 | Төмрийн маркер/Цагаан/ | БНХАУ | ш | 10 | 20,000 | 200,000 | 10,000 | 21,000 | 231,000 | Үгүй |
| 24 | Тэгш ус 60см | БНХАУ | ш | 1 | 50,000 | 50,000 | 1,000 | 5,100 | 56,100 | Үгүй |
| 25 | Гагнуурын баг | БНХАУ | ш | 2 | 100,000 | 200,000 | 2,000 | 20,200 | 222,200 | Үгүй |
| 26 | Гагнуурын держатель | ОХУ | ш | 4 | 50,000 | 200,000 | 4,000 | 20,400 | 224,400 | Үгүй |
| 27 | Гагнуурын багны хар шил /С3:С4/ | БНХАУ | боодол | 2 | 300,000 | 600,000 | 2,000 | 60,200 | 662,200 | Үгүй |
| 28 | Алмаз шил зүсэгч | ОХУ | ш | 4 | 50,000 | 200,000 | 4,000 | 20,400 | 224,400 | Үгүй |
| 29 | Жижиг тасдагч гар | АНУ | ш | 1 | 200,000 | 200,000 | 1,000 | 20,100 | 221,100 | Үгүй |
| 30 | Тэнжээ /2тн/ | ОХУ | | 1 | 400,000 | 400,000 | 1,000 | 40,100 | 441,100 | Үгүй |
| 31 | Тэнжээ /5тн/ | ОХУ | ш | 1 | 400,000 | 400,000 | 1,000 | 40,100 | 441,100 | Үгүй |

# “Грандавто ланд” ХХК

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **32** | Краны строп /5тн/ | ОХУ | хос | **1** | **500,000** | 500,000 | 1,000 | 50,100 | 551,100 | **Үгүй** |
| **33** | Өтгөн тосны гар насос | БНХАУ | ш | **2** | **300,000** | 300,000 | 2,000 | 30,200 | 332,200 | **Үгүй** |
| **34** | Өтгөн тосны хөл насос | БНХАУ | ш | **1** | **400,000** | 400,000 | 1,000 | 40,100 | 441,100 | **Үгүй** |
| **35** | Лантуу /5кг/ | ОХУ | ш | **5** | **50,000** | 250,000 | 5,000 | 25,500 | 280,500 | **Үгүй** |
| **36** | Хүрз /5кг хумбан/ | ОХУ | ш | **30** | **30,000** | 900,000 | 30,000 | 93,000 | 1,023,000 | **Үгүй** |
| **37** | Газовын ком | АНУ | ш | **2** | **300,000** | 600,000 | 2,000 | 60,200 | 662,200 | **Үгүй** |
| **38** | Төмрийн хайч | ОХУ | Ком | **2** | **30,000** | 60,000 | 2,000 | 6,200 | 68,200 | **Үгүй** |
| **39** | Пронцосс 22-36 | ОХУ | ш | **5** | **50,000** | 250,000 | 5,000 | 25,500 | 280,500 | **Үгүй** |
| **40** | Штангенциркуль /0-150/ | ОХУ | ш | **2** | **50,000** | 100,000 | 2,000 | 10,200 | 112,200 | **Үгүй** |
| **41** | молдок /жижиг/ | АНУ | ш | 1 | **500,000** | 500,000 | 1,000 | 50,100 | 551,100 | **Үгүй** |
| **42** | Олс /зузаан/ | ОХУ | ш | 50 | **20,000** | 1,000,000 | 50,000 | 105,000 | 1,155,000 | **Үгүй** |
| **43** | Силиконы буу | БНХАУ | м | 1 | **50,000** | 50,000 | 1,000 | 5,100 | 56,100 | **Үгүй** |
| **44** | Хадаас тавлагч | БНХАУ | ш | 1 | **50,000** | 50,000 | 1,000 | 5,100 | 56,100 | **Үгүй** |
| **45** | Жижиг түлхүүрийн ком 4-20мм | ОХУ | ш | 1 | **200,000** | 200,000 | 1,000 | 20,100 | 221,100 | **Үгүй** |
| **46** | Тусгай түлхүүр | Тайван | ком | 1 | **200,000** | 200,000 | 1,000 | 20,100 | 221,100 | **Үгүй** |
| **47** | Ажилчдын багажны цүнх /Үүрдэг/ | ОХУ | ш | 16 | **100,000** | 1,600,000 | 16,000 | 161,600 | 1,777,600 | **Үгүй** |
| **48** | Холхивч тослох шиприз /Хөдөлгүүрийн холхивч тослох / | ОХУ | ш | 1 | **200,000** | 200,000 | 1,000 | 20,100 | 221,100 | **Үгүй** |
| **49** | Халив /Цахилгааны тусгаарлагчтай/ | АНУ | ком | 14 | **100,000** | 1,400,000 | 14,000 | 141,400 | 1,555,400 | **Үгүй** |
| **50** | Тестерийн шүб | БНХАУ | ком | 12 | **50,000** | 600,000 | 12,000 | 61,200 | 673,200 | **Үгүй** |
| **51** | Хүрзний иш /Модон/ | Монгол улс | ш | 5 | **20,000** | 100,000 | 5,000 | 10,500 | 115,500 | **Үгүй** |
| **52** | 2 дугуйт тэргэнцэр | Монгол улс | ш | 2 | **400,000** | 800,000 | 2,000 | 80,200 | 882,200 | **Үгүй** |
| **53** | Хүрз /5кг хавтгай/ | ОХУ | ш | 10 | **30,000** | 300,000 | 10,000 | 31,000 | 341,000 | **Үгүй** |
| **54** | Хагас автомат гагнуурын аппаратны хошуу / металл/ | БНХАУ | ш | 5 | **300,000** | 1,500,000 | 5,000 | 150,500 | 1,655,500 | **Үгүй** |
| **55** | Өтгөн тосны масленка /8-11мм/ | ОХУ | ком | 100 | **50,000** | 500,000 | 100,000 | 60,000 | 660,000 | **Үгүй** |
| **56** | Аваарын троссын хомут | ОХУ | ш | 10 | **20,000** | 200,000 | 10,000 | 21,000 | 231,000 | **Үгүй** |
| **57** | Аргон гагнуурын ком багаж | БНХАУ | иж бүрдэл | 1 | **500,000** | 500,000 | 1,000 | 50,100 | 551,100 | **Үгүй** |
| | | | | | | 21,660,000 | 1,153,000 | 2,281,300 | 25,094,300 | |

дерт оролцогчийн нэр: **“Грандавто ланд” ХХК**

бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

бан тушаал, нэр: гүйцэтгэх захирал **А.Бүрэнмэнд**

г: Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, сэлбэ 5-р гудамж, 500 тоот.